



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/102


Сангиндалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт “Төсвийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн дундах шүдний өвчлөлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийг 2023 оны 05 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2,600,000 (хоёр сая зургаан зуун мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



О.БАЗАРРАГЧАА

482302205